



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/812

Булган сум

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 49 дүгээр зүйлийн 49.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах тухай дүрэм”-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Булган сумын 6-р баг Залуус хорооллын айл өрхийг төвлөрсөн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбох ажил нь барилга байгууламжийн ажлын зураг төсөл, норм дүрэм, стандартын шаардлагад нийцэж байгаа нь барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 39/2023 дугаар дүгнэлтээр баталгаажсан тул инженерийн шугам сүлжээний зориулалтаар 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс байнгын ашиглалтад оруулсугай.

2. Энэхүү барилга байгууламжийн туршилт тохируулгын хугацааг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл тооцох ба энэ хугацаанд гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалсан эвдрэл, гэмтлийг тухайн ажлын гүйцэтгэгч “Бурхууд” ХХК-ийн хөрөнгөөр засуулах ажлыг захиалагч Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн), ашиглагч “Булган Мээж” ХХК-ийн захирал (Г.Ганбаатар) нарт даалгасугай

3. Инженерийн шугаман байгууламжийн ашиглалтын дүрмийг чанд мөрдөж, барилга байгууламжийн хувийн хэргийн хөтлөлтийг тогтмолжуулан барилга байгууламжид дур мэдэн өөрчлөлт хийх, ашиглалтын горимыг зөрчихгүй ашиглахыг “Булган Мээж” ХХК-ийн захирал (Г.Ганбаатар) -д даалгасугай.

4. Ашиглалтад оруулсан барилга байгууламжийн баримт материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зөвхөн эх хувиар нь хүлээн авч архивын нэгж үүсгэн хадгалахыг Төрийн архив /Д.Батсайхан/-т даалгасугай.

5. Ашиглалтад орсон барилга байгууламжийг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, 14.6-д тус тус заасны дагуу хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

6.Тус барилга байгууламжийг орон нутгийн өмчид бүртгэж авахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  БАРИУН-ЭРДЭНЭ